

ИХ МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ БОДЛОГО: ТҮҮХ, ОРЧИН ҮЕ

Эрдэм шинжилгээний олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах удирдамж

1. Ерөнхий мэдээлэл

Эзэн Чингис хааны байгуулсан Их Монгол улсын 820 жилийн ойд зориулж зохион байгуулах “Их Монгол улсын дипломат бодлого: *түүх, орчин үе*” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж Монголын эзэнт улсын бүс нутаг, олон улсын гадаад бодлого дахь нөлөө байр суурь, дипломат ёс, дэг журам, нөлөөллийн тухай асуудлыг хөндөхөөс гадна тэдний үлдээсэн өвийг судалсан эрдэмтдийн хамтын судалгааг хэлэлцэхэд оршино. Чингис хааны хэрэгжүүлсэн дипломат бодлого, элчийн халдашгүй дархан байдал, олон улсын гэрээ хэлэлцээрийн зарчим, хэм хэмжээ, олон улсын харилцаанд мөрдөгдөж байсан ёс зүйн хэм хэмжээг орчин үеийн олон улсын эрх зүйн онол, практиктай уялдуулан хэлэлцэх зорилгоор уг олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах болно.

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурал нь Евразийн XIII зууны улс төрийн дэг журам ба өнөөгийн олон улсын эрх зүйн тогтолцооны түүхэн залгамж холбоог тодруулах, онцлогыг тодорхойлох, харилцан нөлөөллийг дүгнэн хэлэлцэхэд чиглэнэ.

2. Зорилго

- Чингис хаан болон түүний угсааны хаад, язгууртны үеийн дипломат харилцааны институцийн онцлогийг тодорхойлох, бодлогыг тодруулах
- Дипломат ёс горим, дэг журам, элчин харилцааны үйл ажиллагааны түүхэн үндсийг тодруулах, уламжлагдсан байдлыг харьцуулан судлах
- Их Монгол Улсын “Их засаг” хууль ба олон улсын нийтийн эрх зүйн зарчмуудтай харьцуулан судлах, дипломат харилцааны эрх зүйн тогтолцоонд хэрхэн уламжлан үлдснийг тодорхойлох
- Монголчуудын бүс нутаг, дэлхийн дипломат харилцаанд үзүүлсэн нөлөө, байр суурийг орчин үеийн олон улсын дипломат эрх зүйн хөгжилд оруулсан хувь нэмэр болон нөлөөг үнэлэх, харьцуулах

3. Хэлэлцэх үндсэн чиглэл

1. Чингис хаан ба дипломат албаны институцжилт
2. Монголын эзэнт улсын элчин харилцаа: түүхэн эх сурвалж ба орчин үеийн зохицуулалт
3. XIII зууны олон улсын харилцаа *jus gentium*-ийн ойлголт ба “Их засаг” ба олон улсын эрх зүйн үндсэн зарчмууд
4. Дипломат ёс зүйн уламжлал ба Монгол улсын гадаад бодлого
5. Орчин үеийн дипломат эрх зүй ба түүхэн туршлага

4. Оролцогчид

- Олон улсын эрх зүй, түүх, дипломат судлалын эрдэмтэн, судлаачид
- Гадаад, дотоодын их, дээд сургуулийн эрдэмтэн судлаачид

5. Илтгэлд тавигдах шаардлага

- 8–12 хуудас (A4)

- Times New Roman, 12 pt, мөр хоорондын зай 1.5
- Chicago ишлэлийн стандарт
- 200–250 үгтэй англи хураангуй
- 5–7 түлхүүр үг
- Шинэлэг судалгааны үр дүнтэй байх

6. Хэл

Монгол, Англи

7. Хугацаа

- Хураангуй илгээх: 2026.06.01
- Хариу мэдэгдэх: 2026.6.15
- Бүрэн илтгэл: 2026.08.30
- Хурал: 2026.09.18
- Улаанбаатар хот

8. Зохион байгуулагч

- Монгол Улсын Их сургуулийн УТСОУХНУС, Чингис хаан Үндэсний музей, Чингис хаан судлалын Олон Улсын Холбоо
- Холбоо барих:

МУИС-ийн УТСОУХНУС-ийн ОУХ-ны тэнхмийн профессор Ж. Баттогтох

Утас: 99057895

Имайл хаяг: battogtokh@num.edu.mn